

Шалгалт хийсэн тухай

Хяналт шалгалтын зорилго

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, Булган аймгийн Засаг даргын баталсан 2017 оны 05 сарын 22-ны өдрийн 1/14 дүгээр удирдамжийн дагуу Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон бусад холбогдох дүрэм, журам, тушаалуудын хэрэгжилтийг хангуулж, үндсэн үйл ажиллагааны байдал, зохион байгуулалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны байдлыг шалгаж, ололт амжилтыг бататгаж, зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино.

Шалгалтанд хамрагдсан байгууллага, бүрэлдэхүүн, хугацаа

Хутаг-Өндөр сумын “Гацуурхан” цэцэрлэгийн 2015, 2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ж.Оюун 2017 оны 05 сарын 25-аас хуанлын 5 хоногийн хугацаанд багтаан гүйцэтгэв.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, шалтгаан

1. Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2014 оны 10 сарын 27-ны өдрийн А/140 дугаар “Цалин шинэчлэн тогтоох тухай” захирамжийг үндэслэн эрхлэгч Ж.Ариунаагийн шалгуур үзүүлэлтээр ажлыг үнэлж дүгнэлгүй тогтмол нэмэгдэл мэтээр сар бүр үндсэн цалингийн 25 хувиар тооцож 2015 оны 1-6, 8-12 саруудад 1875.1 мянган төгрөг, 2016 оны 1-6, 8-9 саруудад 1244.6 мянган төгрөг, эрхлэгчийн тушаалыг үндэслэн арга зүйч Р.Оюумаад үндсэн цалингийн 20-25 хувиар тооцож 2015 оны 1-6, 9-12 сард 1095.2 мянган төгрөг, 2016 оны 1-5, 9 сард 912.9 мянган төгрөгийн, нярав Х.Шижирбаатарт үндсэн цалингийн 20 хувиар тооцож 2015 оны 1-4 сард 335.0 мянган төгрөг, 2016 оны 1, 10, 12 сард 256.4 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл цалин тус тус олгосон нь Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16.5.5-д /Төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна./, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./, Засгийн газрын 1995 оны 96 тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 4-т /Ур чадварын нэмэгдлийг олгох, олгож байгаа нэмэгдлийн хэмжээг нэмэгдүүлэх, бууруулах, хасах асуудлыг энэ журмын 2,8-д заасан шалгуурыг үндэслэн тухайн

байгууллагын эрх баригчийн тушаалаар шийдвэрлэнэ/, Монгол улсын Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтрасан 1996 оны 63/104 дүгээр тушаалаар баталсан журмын 5-д /Ажилтанд олгож байгаа ур чадварын нэмэгдлийг заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байна./, 6-д /энэхүү нийтлэг журмыг үндэслэн байгууллагын захиргаа нь тухайн албан хаагчид эрхэлж буй ажлын үр дүнгээр ур чадварын нэмэгдэл олгох бусад шалгуур үзүүлэлт, нэмэгдлийн хэмжээг тусгасан журмыг боловсруулан баталж мөрдөнө./ БСШУСайд, Нийгмийн хамгааллын хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 2010 оны 362/112/183 дугаар тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн 7-д /Багш ажилтны ур чадварыг хагас жил тутам үнэлж дүгнэнэ./ заасан заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй.

2. 2016 оны 11 сарын 15-нд Рояал кинг констракшн ХХК-иас 1495.0 мянган төгрөгөөр зөөврийн компьютер худалдан авч, үнийг шилжүүлэхдээ 1498.0 мянган төгрөгөөр буюу 3.0 мянган төгрөг илүү шилжүүлсэн.

3. Орлогын баримтаас бусад анхан шатны баримтуудыг дугаарлаагүй, шаардах хуудсыг буруу хөтөлсөн, аж ахуйн материалын тайланд цэвэрлээ, засварын материалыг тусгаж, зарцуулсан, үндсэн хөрөнгийг “Үндсэн хөрөнгө хүлээн авах, шилжүүлэх баримт”-аар хүлээн аваагүй.

4. Хүнс, бараа материалын агуулахын бүртгэл хөтлөөгүй, хүнсний зарлагын түүвэр хийсэн, шатахууны тайлан гаргадаггүй, авсан шатахууны хэмжээ, мөнгөн дүнгээр жолоочийн замын хуудас бичдэг, жолоочийн тооцоог бодож акт үйлдээгүй,

5. Цалин олгох болон гарт олгох хүснэгтэд багш, ажиллагсдын гарын үсэг зурагдаагүй, хүн нэг бүрт олгож буй цалингийн хүснэгт өгдөг гэж байгаа ч санхүүгийн баримтанд хавсаргаагүй. /2015 оны 01 сараас бусад саруудад/

6. Ажил гүйцэтгэх гэрээгээр байгууллагын гадна болон дотор урсгал засварын ажлыг гүйцэтгүүлж байгаа ч хүлээн авсан акт үйлдээгүй.

7. 2015 онд БСУГазраас тоглоом авч ирэх тээврийн хөлсний 175.0 мянган төгрөгийг Мөнхтуяагийн, 12 сард Able soft компанийн ажилтан Баасансүрэнгээр вэб хуудас нээлгэсний ажлын хөлсөнд 350.0 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн ч анхан шатны баримтуудыг санхүүгийн баримтанд хавсаргаагүй байна.

Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгсөн байдал

- Анхан шатны баримтуудыг оны эхнээс дугаарлах, анхан шатны баримт хөтлөлтийн талаар анхан шатны баримт хөтлөлтийн талаар санхүү бүртгэлийн 2 хүнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

- Улсын байцаагчийн 2 актаар 1575.0 мянган төгрөгийн төлбөр тогтоов.
- Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 1 албан шаардлага үйлдэв.

Дүгнэлт

Шалгагдсан онуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагааны анхан шатны баримтын бүрдүүлэлт, хөтлөлт хангалттай байна.

Санхүүгийн баримт материалд байгууллага дотооддоо хяналт хийгдээгүйгээс нийтлэг зөрчлүүд илэрч байна.

Цаашид авах арга хэмжээний санал

- Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийг уншиж судлаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх
- Дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх
- Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу албан ёсны баримтыг үндэслэн зарцуулж байх
- Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, давтан гаргахгүй байхаар тодорхой ажил зохион байгуулж, акт, албан шаардлагын биелэлтийг хангах

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.ОЮУН

